БАТЛАВ. АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Д.БАТЗОРИГ

Завхан аймгийн Улиастай сумын Өлзийт багийн
"21-р зуун 800 айлын жишиг хороолол"-ын цахилгаан хангамжийн

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо. 2021.03.12 № 22/2021/252 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	***ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР*** *Завхан аймаг, Улиастай сум,* ***"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК*** *Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг*
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	*Завхан аймаг, Улиастай сум, Өлзийт баг*
3. Ажил үйлчилгээний зориулалт	*"21-р зуун 800 айлын жишиг хороолол"-ын цахилгаан хангамж*
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	*- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль* *- Завхан аймгийн засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 2/258, 03 дугаар сарын 19-ны 1/345 тоот албан бичиг,* *- "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 21 тоот албан бичиг,* *- Эрчим хүчний яамны цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсгийн 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн товч тэмдэглэл*
5. Суурилагдсан чадал	*10 кВ-ын хуваарилах байгууламж, 10/0.4 кВ-ын 2х400 кВА хүчин чадалтай 2 ком дэд станц*
6. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	*6.1 RS 485 интерфейсийн шаардлага хангасан, "IEC61107", "IEC62056" холболтын протоколтой, Монгол улсын Стандарт, Хэмжилзүйн Газраар баталгаажиж, ашиглахыг зөвшөөрсөн, санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур тавих, тоолуурын нэгдсэн системд холбох.*
7. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага	*7.1 Хэрэглэгчийн ачаалалд тохирсон коэффициент бүхий Монгол Улсын стандарт, шаардлага хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг*

бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,

8. Холбогдох цэг

8.1 110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламжийг вакуум таслуур бүхий 2 гаргалгаагаар өргөтгөн, хос кабель шугам татаж, шинээр баригдах 10 кВ-ын хуваарилах байгууламж /РП/-г тэжээх.

9. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага

9.1 110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламжид суурилуулах гаргалгааны ячейкууд нь дараах шаардлагыг хангасан байх.

9.1.1 Олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалттай, механик болон цахилгаан хоригтой, нумын хамгаалалт, газардлагын хамгаалалтын функц, шинийн логик хамгаалалттай байх ба ба АЧР, АПВ г.м автоматик, цахилгаан байгууламжийн дүрэм (БД43-101-03) болон ТАД-д заасан бүх төрлийн хамгаалалтыг суулган программчлах боломжтой байх.

9.1.2 Халаагуурын систем, температурын датчик, кабелийн холболтын камерт нумын хамгаалалт, газардуулгын дохиолол, фазын дараллын индикатортай, ячейкны ар талаас кабелийн үзүүр, гүйдлийн траснформаторт үзлэг шалгалт хийх цонх зэргээр тоноглогдсон байх, тэг дараллын гүйдлийн трансформатор суурилуулж, газардлагын хамгаалалтыг оруулах,

9.1.3 Хэрэглэгчийн өсөн нэмэгдэх ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалттай гүйдлийн трансформатор, реле хамгаалалт, хэмжүүр, тоолуурыг тооцсон ороомогтой байх, кабелийн үзүүрт тооцооны үндсэн дээр хэт хүчдэл хязгаарлагч /ОПН/ сонгох,

9.1.4 Тус ячейкуудад тэсэрдэг галын хор байрлуулах /Бурон-2.0, ОСП-1/

*9.2 Шинээр баригдах 10 кВ-ын кабель шугамын 3*240 мм^2 хөндлөн огтлол бүхий дамжуулагчтай байх. Трассыг зураг төслийн шатанд ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК, орон нутгийн холбогдох байгууллагатай зөвшилцөн сонгох,*

9.3 Шинээр баригдах 10 кВ-ын хуваарилах байгууламж /РП/ нь дараах шаардлагуудыг хангасан байх. Үүнд:

9.3.1 Шинээр баригдах хуваарилах байгууламж нь 10 кВ-ын оруулгууд ба гаргалгаануудыг вакуум таслуур, секц холбогч вакуум таслуур, секц холбогч салгуур, дотоод хэрэгцээний болон хүчдлийн трансформаторууд тусдаа ячейкуудтай байх,

9.3.2 10 кВ-ын гаргалгааны ячейк нь энэхүү техникийн нөхцөлийн 9.1-д заасан шаардлагыг хангасан байх,

9.3.3 Тус ячейкуудад кабелийн туннель болон ячейкуудад тэсэрдэг галын хор байрлуулах /Бурон-2.0, ОСП-1/

9.3.4 10 кВ-ын хуваарилах байгууламжийн гаргалгааны тоог хэрэглээ, ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгож, ашиглагч байгууллагатай зөвшилцөх,

9.3.5 10 кВ-ын ХХБ-ын I, II секцийн ерөнхий шин нь бүрээстэй, байнгын газардуулын хутгатай байх,

9.3.6 Хуваарилах байгууламжийн барилга нь тоосгоор баригдсан байх шаардлагатай бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар барих,

*9.4 10 кВ-ын хуваарилах байгууламжаас 3*240 мм^2 хөндлөн огтлол бүхий дамжуулагч бүхий 10 кВ-ын хос кабель шугам татаж, 10/0.4 кВ-ын 2х400 кВА хүчин чадал бүхий 2 дэд станц /ХТП/ барих. Зураг төсөл боловсруулах шатанд холболтын схем, горим ажиллагааг ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах,*

9.5 Дэд станцын 10/0.4 кВ-ын трансформаторууд нь хүчдэл тохируулгын 5 шатлал бүхий олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

9.7 Хуваарилах байгууламж, дэд станцын 10 кВ, 0.4 кВ-ын оруулга, гаргалгааны шугам, тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцооны дагуу суурилуулах, зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллагатай зөвшилцөх, тавил тооцоог тус компаниар хийлгүүлэх,

9.10 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

9.11 Хуваарилах байгууламж, дэд станцуудад галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах,

9.13 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага "АУЭХС" ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах,

10. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага

10.1 Энэхүү техникийн нөхцлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автотикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь "Бодлогын бичиг баримт батлах тухай" Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан "Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар бариментлах бодлогын баримт бичиг", "Эрчим хүчний салбарт бариментлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг"- шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага АУЭХС ТӨХК-тай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх.

10.2 Шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг

	холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага АУЭХС ТӨХК-тай зөвшилцөн сонгох.
	10.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хийж, АУЭХС ТӨХК-тай зөвшилцөн хийлгэх.
	10.4 Техникийн нөхцөлд заасан нөхцөл шаардлагыг хангах
11. Реактив чадлын зохицуулалт	-
12. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	-
13. Нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж	*13.1 Зургийн даалгаврыг Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газраас авах.*
	13.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Засгийн 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөн байх.
	13.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчимын схем, хоёрдогч хэлхээний зургийг АУЭХС ТӨХК-тай зөвшилцөх.
14. Гэнэтийн гэмтэл саатал, аваарийн үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	-
15. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	*15.1 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.8 "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.*
16. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа	*16.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.9-д заасны дагуу 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл / 1 жилийн хугацаанд/ хүчинтэй.*
	16.2 16.2 Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг боловсруулсан байна.
17. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	*17.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий хийлгэж, нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,*

17.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,

17.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм" (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,

17.4 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж болох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй,

18. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт

18.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;

2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.

18.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд

АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ОРЛОГЧ ДАРГА:

ТУС ЯАМНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Ш.ГАНЗОРИГ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ТУС ЯАМНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ М.ГАНСҮХ